



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2012 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурал  
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын хөлөг онгоцны бүртгэл” хамтарсан компанийн Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлыг 10 дугаар сарын 15-19-ний дотор Улаанбаатар хотноо зарлан хуралдуулсугай.

2. Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хуралд Монголын талыг төлөөлөн оролцох бүрэлдэхүүнийг дор дурдсанаар томилсугай. Үүнд:

Ё. Манлайбаяр	Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Х. Энхбаатар	Далайн Захиргааны дарга
Т. Болдбаатар	Тээврийн хэрэгслийн оношилгоо, хяналт, зохицуулалтын албаны захирал
Б. Алтан-Од	“Монголын хөлөг онгоцны бүртгэл” хамтарсан компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгч

3. Хувь нийлүүлэгчдийн хуралд оролцох бүрэлдэхүүний ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

4. “Монголын хөлөг онгоцны бүртгэл” хамтарсан компанийн хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулж, Хурлаас гарсан шийдвэр, тайланг 10 дугаар сарын 25-ны дотор яамны удирдлагууд танилцуулахыг Далайн Захиргаа /Х.Энхбаатар/-нд үүрэг болгосугай.



А.ГАНСҮХ

Зам, тээврийн сайдын 2012 оны  
10 дугаар сарын 4-ны өдрийн  
39 дугаар тушаалын хавсралт



Монголын хөлөг онгоцны бүртгэл хамтарсан  
компанийн хувь нийлүүлэгчдийн хуралд Монголын  
талыг төлөөлөн оролцох бүрэлдэхүүний  
ажлын удирдамж

Хуралдаанд оролцох бүрэлдэхүүн дараах удирдамжийн дагуу ажиллана. Үүнд:

1. Монголын талын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлөх, шинээр батлах;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг чөлөөлөх, шинээр томилох;
4. Хамтарсан компанийн Гүйцэтгэх захирлыг томилох, түүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах;
5. Компанийн санхүүгийн үйл ажиллагааг эрхлэн явуулах нягтлан бодогч, туслах бүртгэгчийг шинээр томилох;
6. Удирдамжийн дагуу ажилласан ажлын тайланг 10 дугаар сарын 31-ны дотор Бүртгэлийн боомтын дарга, удирдлагуудад танилцуулна.